


МИШЭЭЛ БАЙГАЛЬ ОРЧИН, ТАНИН МЭДЭХҮЙН ХҮРЭЭЛЭН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

НЗАА, НЗДТГ-ын дэмжлэгтэйгээр “Мишээл групп” ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд 100 гаруй харилцагчидтайгаа хамтран нэг ч бут, сөөг хөндөлгүйгээр байгалийн жимийг ашиглан 110’000м² ногоон байгууламжийг 2.1 тэрбум төгрөгөөр тохижуулав.




Уг төслийн зорилго нь:


1. Экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, ургамал болон амьтны аймгийн тоог тогтвортой байлгах, нөхөн сэргээх
2. Туул голын сав газрын урсцыг нэмэгдүүлэх зорилгоор жил бүр мод тарьж, байгаль орчны таатай нөхцөлийг бүрдүүлэх
3. Иргэдийн амарч зугаалах, алхах, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор зориулалтын тохижилттой ногоон байгууламжийн тоог нэмэгдүүлэх
4. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, байгалийн ухааны чиглэлээр сурч байгаа оюутнуудад практик сургалт хийх зориулалт бүхий ургамлын лаборатори байгуулах.



Энд хүүхэд залууст зориулсан сагсан бөмбөг, элсний волейболын талбайтай, хөгшид буурлуудад зориулсан дасгал хөдөлгөөний эко төхөөрөмжүүдтэй, нялхас нярайд зориулсан саравч, сүүдрэвч, савлуур, гулсуур, бага насны хүүхдүүдэд зориулсан элсэн талбайтай.



Аялагч, амрагчдад зориулсан ая тухтай ширээ сандалтай бөгөөд хүүхдийн тэрэгтэй ээжүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу замтай. Мөн Туул голын тогтуун дөлгөөн урсгалыг харан амрах боломжтой террастай тул иргэд олноор ирж ая тухыг мэдэрч байна.



Голын эргийн тавцан

Улс нийтийн баяр, арга хэмжээнүүд болон 4 улирлын байдлаас хамаарч эвент, үзүүлбэрүүд, эргэдэг хийлдэг тоглоомууд, астропарк буюу одон орны гэр, амьтны хүрээлэнг ажиллуулж байна.



Өдөр тутамд тогтмол хөтөлбөр, арга хэмжээ зохион байгуулдаг

Өвөл мөсөн хотхон, гэрэлт харгуйг бий болгож хавар, намар нь мэргэжлийн коллеж, сургуулийн оюутнуудад зориулан практик дадлага хийх боломжийг олгодог. Мөн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад байгалийн ухааны хичээлийн практик орчинг бий болгож өгсөн.

